

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ГИШҮҮНД НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ

Товч удирдамж: Нэр дэвших тухай хүсэлт гаргахдаа энэхүү загварт асуусан асуулт, шаардсан мэдээлэл бүрийн доор /ард/ хариултаа үнэн зөв бичнэ. Компьютерын програм ашиглаж бичсэн хүсэлтийг цаасаар хэвлэж гарын үсэг зурах бөгөөд уг эх хувь, түүний хавсралт мөн Word-ын файлыг цахим шуудангаар тус тус Байнгын хороонд явуулна.



НЭГ. НЭР ДЭВШИГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА, НИЙТЛЭГ ШААРДЛАГА

1.1	Эцэг/эхийн нэр: Ургийн овог: Нэр: Хүйс: Төрсөн он: Төрсөн газар: Иргэний харьяалал: Одоо оршин суугаа аймаг/нийслэл, сум/дүүрэг: <i>/Мэдээлэл гаргагчийн зөвшөөрлөөр/</i>	ЦЭЦЭГМАА ИНДРАНИЛ УРТНАСАН ЭРЭГТЭЙ 1974 ӨМНӨГОВЬ АЙМАГ, ХҮРМЭН СУМ МОНГОЛ УЛС НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 15 ДУГААР ХОРОО
1.2	Нэр дэвших тухай хүсэлт гаргаж буй албан тушаал СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ГИШҮҮН	
1.3	Иргэний харьяалал Монгол Улсын иргэн мөн эсэх /тийм, эсхүл үгүй гэж бичих/ Монгол Улсаас өөр улсын иргэний харьяалалтай байсан эсэх /тийм, эсхүл үгүй гэж бичих/.	ТИЙМ ҮГҮЙ
1.4	Боловсрол Дээд боловсрол эзэмшсэн сургууль тус бүрийг сүүлд төгссөн сургуулиас нь эхлэн он дарааллаар жагсааж, холбогдох нотлох баримтыг хавсаргана. Сургууль тус бүрд суралцсан хугацаа, авсан зэрэг, огноог бичнэ. УДИРДЛАГЫН АКАДЕМИ 2000-2001, Удирдахуйн ухааны магистр, Дугаар № 2001/69 МОНГОЛ УЛСЫН ТЕХНИКИЙН ИХ СУРУУЛЬ 1992-1997, Бизнесийн удирдлагын бакалавр, Мэдээллийн технологийн менежмент мэргэжил, Дугаар №17091 МОНГОЛ УЛСЫН ТЕХНИКИЙН ИХ СУРУУЛЬ 1992-1995, Программ хангамж мэргэжил, Программ зохиогч цол, Дугаар №15547	
1.5	Эрхэлсэн ажил Их, дээд сургууль төгссөнөөс хойш эрхэлсэн ажлыг тодорхойлон бичнэ. Ажилласан байгууллагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар жагсаах бөгөөд ажил олгогч /эсхүл, удирдах албан тушаалтан/-ийн нэр, хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, цахим хуудас болон ажлын байрны нэрийг бичнэ.	

№	БАЙГУУЛЛАГА	ЭРХЭЛСЭН АЖИЛ	АЖИЛД ОРСОН	АЖЛААС ГАРСАН
1	Монгол Улсын Их Хурлын Тамгын газар	Гүйцэтгэл, бүтээмжийн хяналтын хэлтэс, Ахлах зөвлөх	2026.06.09	
2	Нийгмийн эрүүл мэндийн даатгалын үндэсний нийгэмлэг	Гүйцэтгэх захирал	2025	2026
3	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн Яам	Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч	2025.03.26	2025.08.18
4		Бүтээмж, мэдээллийн технологийн хэлтсийн дарга	2025.03.10	2025.09.24
5		Сайдын зөвлөх	2024.07.29	2025.03.07
6	Ардчилсан намын Хэрэг эрхлэх газар	Дэд дарга (орон тооны)	2021.01.31	2023.04.20
7		Улс төрийн бодлого, намын байгуулалтын газрын дарга	2017.02.17	2020.06.29
8	Нийгмийн эрүүл мэндийн даатгалын үндэсний нийгэмлэг	Гүйцэтгэх захирал	2016	2017
9	Нийгмийн даатгалын ерөнхий газар	Дарга, Нийгмийн даатгалын Улсын Ерөнхий байцаагч	2012.09.27	2015.12.30
10	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам	Төрийн захиргааны удирдлагын газрын дарга	2012.08.20	2012.09.27
11	Өмнөговь аймаг	Засаг даргын орлогч	2010.11.24	2012.05.30
12	Нийгмийн даатгалын ерөнхий газар	Дэд дарга	2005.01.10	2010.12.01
13	“Монголын хайлуур жонш” хоршоо	Дарга	2003	2005
14	Индранилсофт ХХК	Захирал	2002	2003
15	АПУ ХК	Дэд захирал	2002	2002
16	“Монголросцветмет” нэгдэл	Салбар “Дружба интернэшнл” компанийн Гүйцэтгэх захирал	2001	2002
17		Программист инженер, Боловсон хүчин-нийгмийн бодлогын хэлтсийн орлогч дарга	1997.07.01	2001.12.01

1.6	Улс төрийн болон намын удирдах, гүйцэтгэх албан тушаал Сүүлийн таван жил улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах, гүйцэтгэх албан тушаал эрхэлж байсан эсэхийг бичих. /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, ямар албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа, эсхүл эрхэлж байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/. Тийм
------------	--

1	Ардчилсан нам	Дэд дарга (орон тооны бус)	2023.08.30	2025.03.10
2		Дэд дарга (орон тооны)	2021.01.31	2023.04.20
3		Хэрэг эрхлэх газрын Улс төрийн бодлого, намын байгуулалтын газрын дарга	2017.02.17	2020.06.29

1.7	<p>Эрүүгийн хариуцлага Эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах/ Үгүй</p>
1.8	<p>Яллагдагчаар татагдсан эсэх Яллагдагчаар татагдсан эсэх /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол товч тайлбарыг бичих/.</p>
1.9	<p>Сахилгын шийтгэлийн талаар Сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж эсхүл огцорч байсан эсэх /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/. Үгүй</p>
1.10	<p>Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар -Төрийн бус байгууллагад эрхэлж байсан албан тушаал, гүйцэтгэсэн чиг үүрэг, огноог хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичнэ. Сургалт, зөвлөх үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Нийгмийн эрүүл мэндийн даатгалын үндэсний нийгэмлэг” ТББ-ын Гүйцэтгэх захирлаар 2016 - 2017, 2026 онд ажиллаж байсан.</p>
1.11	<p>Нэр дэвшигч нь хэрэв байгаа бол доор дурдсан мэдээллийг бичнэ</p> <p>-Өөрийн боловсруулсан, хянасан судалгааны ажил, ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ.</p> <p>-Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ.</p> <p>-сүүлийн таван жилийн хугацаанд хэлэлцүүлсэн лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, ярианы товч утга, огноо, газар, танилцах арга замыг бичнэ. Тухайн илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч утгыг бичнэ.</p> <p>-сүүлийн таван жилийн хугацаанд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлага, нийтлэлийг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлага, нийтлэлүүдийн огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэг, нийтлэлийг хуулбарлан өгнө.</p> <p>Жич: Дээр дурдсан материал тус бүрээс нэгийг хавсаргах бөгөөд боломжтой бол цахимаар үзэх линкийг тусгана.</p>

I. ХЭВЛҮҮЛСЭН НОМ			
1	Миний ажил амьдралын 1111 өдрийн тэмдэглэл	2015	ISBN: 978-9997-33-224-0, Үйл ажиллагааны тайлан, нийтлэл
2	Загийн зангилаа	2021	ISBN: 978-9919-24-432-3, Нийгэм, улс төрийн нийтлэлийн эмхэтгэл

II. БЭЛДЭХЭД ОРОЛЦСОН АЛИВАА ХУУЛЬ ТОГТООМЖ, ДҮРЭМ, ЖУРАМ, ШИЙДВЭР, ТАЙЛАН, ЗӨВЛӨМЖ

1	Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого (2015-2030)	2015	УИХ-ын 2015-06-16-ны өдрийн 53 тоот тогтоолоор батлагдсан.
2	Тэтгэврийн шинэчлэлийн талаар авах арга хэмжээний тухай		Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн төслийг 2018 онд хамтран боловсруулж, Засгийн газарт хүргүүлсэн.
3	“Стандарттай байгаль орчин” үйл ажиллагааны төлөвлөгөө		ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр (2024-2028)-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарын шинэчлэлийн хөтөлбөрийг “Стандарттай байгаль орчин” үйл ажиллагааны төлөвлөгөө нэртэйгээр боловсруулж, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025-04-25 өдрийн 240 тоот тушаалаар баталуулсан.

III. ХЭВЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛД ӨГСӨН ЯРИЛЦЛАГА, НИЙТЛЭЛ

1	“Уур амьсгалын өөрчлөлт” итгэл https://www.facebook.com/share/v/1J6bbEzS3x/	2025	Байгальтайгаа дасан зохицох, зэрлэг ан амьтантай зэрэгцэн орших нь өнөөгийн хүн төрөлхтний байгаль хамгааллын шинэ хандлагын тухай
2.	“2028 он хүртэл 300 МВт нарны, 200 МВт салхины цахилгаан станц барих, эрчим хүчний хадгалалт, дамжуулах дэд бүтцийг хөгжүүлнэ” ярилцлага	2025	“Өдрийн сонин”-ы 2025-07-24-ны өдрийн тэргүүн нүүрт нийтлэгдсэн

ХОЁР. ХИЙХ АЖИЛ, НЭР ДЭВШСЭН ҮНДЭСЛЭЛЭЭ БИЧСЭН ТАЙЛБАР

2.1	<p>Тухайн албан тушаалд томилогдвол хийх ажил, уг албан тушаалд нэр дэвшсэн үндэслэлээ тайлбарлаж тодорхой, ойлгомжтой бичнэ /500-1000 үгэнд багтаана/.</p> <p>ҮНДЭСЛЭЛ</p> <p>Монголын ард түмэн ардчилсан хөгжлийн замыг сонгож, 1992 оны Үндсэн хуулиар баталгаажуулсан билээ.</p> <p>Ардчилсан тогтолцооны үнэт зүйлсийн нэг бөгөөд Ардчилсан Үндсэн хуулийн үзэл санааны тулгуур зарчим нь төрийн эрх мэдлийн эх сурвалж нь ард түмэн байх явдал юм.</p> <p>Энэхүү зарчим нь иргэдийн оролцоотой, чөлөөт, шударга, бүх нийтийн сонгууль зохион байгуулсанаар бодит амьдралд хэрэгжиж, биелэлээ олдог. Иймээс сонгуулийн байгууллагын үйл ажиллагааг зөвхөн хууль хэрэгжүүлэх техникийн шинжтэй ажил бус, ардчиллын үнэт зүйлсийг хамгаалах, иргэдийн үндсэн эрхийг хангах төрийн онцгой хариуцлага гэж ойлгож байна.</p>
-----	--

Сонгуулийг санал хураах нэг өдрийн үйл ажиллагаа бус, харин төлөвлөлт, бэлтгэл, хэрэгжилт, үнэлгээ, тасралтгүй сайжруулалтыг хамарсан урт хугацааны институцийн үйл явц буюу процесс гэж үзэж байна. Сонгуулийн чанар нь зөвхөн санал хураалтын өдрийн зохион байгуулалтаар хэмжигдэхгүй бөгөөд сонгогчдын боловсрол, оролцогч талуудын тэгш боломж, олон нийтийн итгэл, байгууллагын ил тод байдал, хариуцлагын түвшнээр тодорхойлогдох юм.

Иймээс сонгуулийн байгууллагын үйл ажиллагааг зөвхөн хууль, журмын хэрэгжилтээр хязгаарлах бус, сонгуулийн бүх оролцогч талуудын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг тэнцвэртэй хангах, иргэдийн итгэлийг бэхжүүлэх, төрийн үйлчилгээний чанарыг сайжруулах менежментийн тогтолцоонд тулгуурлан хөгжүүлэх шаардлагатай юм.

Монголын ард түмний сонгосон хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийн үнэт зүйлстэй нийцүүлэн сонгуулийн байгууллага нь хяналт, шаардлага, албадлагын шинж давамгайлсан байгууллагаас илүүтэй иргэдэд нээлттэй, хүртээмжтэй, иргэн төвтэй үйлчилгээ үзүүлдэг байгууллага болон төлөвших ёстой. Иргэдийн сонгох, сонгогдох эрхийг хангах нь зөвхөн хууль хэрэгжүүлэх асуудал бус, харин иргэдэд ойлгомжтой, хүртээмжтэй, итгэл төрүүлэхүйц орчин бүрдүүлэх асуудал юм.

Сонгуулийн байгууллагын өмнө тулгамдаж буй чухал асуудлын нэг нь менежментийн тогтолцооны боловсронгуй бус байдал болон институцийн тогтвортой байдлыг хангах асуудал гэж үзэж байна. Тиймээс олон улсын сонгуулийн стандарт, шилдэг туршлагыг үе шаттайгаар нэвтрүүлэх нь зөвхөн ач холбогдолтой төдийгүй зайлшгүй шаардлагатай алхам юм.

Олон улсын стандарт нь байгууллагын үйл ажиллагааг хувь хүний ур чадвар, туршлагаас хэт хамааралтай байдлаас гаргаж, тогтвортой, ил тод, хариуцлагатай, мэргэжлийн институци болгон төлөвшүүлэх үндэс суурийг бүрдүүлнэ. Ингэснээр сонгуулийн байгууллагын менежментийн соёл, хандлага, үйл ажиллагааны чанарыг шинэ түвшинд гаргах боломж бүрдэнэ.

Мөн сонгогчдын боловсролыг дээшлүүлэх асуудлыг сонгуулийн байгууллагын байнгын чиг үүргийн салшгүй хэсэг болгон хөгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Иргэд мэдээлэлтэй, хариуцлагатай, хараат бус сонголт хийх боломжтой байх нь сонгуулийн шударга байдлын чухал баталгаа юм. Иймээс сонгуулийн боловсролыг зөвхөн сонгуулийн үеийн ажил биш, харин тасралтгүй хэрэгждэг олон нийтийн боловсролын тогтолцоо болгон хөгжүүлэх нь зүйтэй байна.

Дижитал шилжилт эрчимтэй өрнөж буй өнөө үед сонгуулийн үйл ажиллагаанд мэдээллийн технологийн шийдлүүдийг нэвтрүүлэх нь цаг үеийн шаардлага болж байна. Гэвч технологийн шинэчлэлийг зөвхөн боломж талаас нь бус, мэдээллийн аюулгүй байдал, кибер эрсдэл, мэдээллийн үнэн зөв байдал, иргэдийн итгэл зэрэг хүчин зүйлтэй уялдуулан авч үзэх шаардлагатай. Иймээс сонгуулийн байгууллагын технологийн чадавхийг бэхжүүлэхийн зэрэгцээ эрсдэлийг урьдчилан тооцож, удирдах тогтолцоог хөгжүүлэхэд онцгой анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзэж байна.

Шинэчлэгдсэн Улс төрийн намын тухай хууль хэрэгжиж эхэлснээр сонгуулийн төв байгууллагын чиг үүрэгт улс төрийн намын мэдээллийн нэгдсэн бүртгэл хөтлөх, намын санхүүжилтийн тайланг хянах, төрийн санхүүжилтийг тооцож, шийдвэрлэх, санхүүгийн ил тод байдлыг хангах, олон нийтэд мэдээлэх, намуудад арга зүй, сургалт зөвлөгөө үзүүлэх зэрэг асуудлуудыг хариуцуулсан. Энэ нь сонгуулийн төв байгууллага

зөвхөн сонгууль зохион байгуулагч бус, харин улс төрийн орчны шударга өрсөлдөөн, ил тод байдал, ардчиллын чанарыг дэмжигч институци болон хөгжих шаардлага байгааг харуулж байна.

Иймээс сонгуулийн төв байгууллага нь иргэдийн эвлэлдэн нэгдэх эрх, сонгох, сонгогдох эрхийг хангах үндсэн чиг үүргээ шинэ нөхцөл байдалд нийцүүлэн хэрэгжүүлж, олон нийтийн өсөн нэмэгдэж буй хүлээлтэд нийцсэн, мэргэжлийн, хараат бус, хариуцлагатай байгууллага байх шаардлагатай болж байна.

Миний хувьд Сонгуулийн Ерөнхий Хорооны гишүүний бүрэн эрхийг хэрэгжүүлэхдээ ардчиллын үнэт зүйлсийг хамгаалах, институцийн хараат бус байдал, тогтвортой хөгжлийг хангах, олон улсын сайн туршлага, стандартыг нэвтрүүлэх, сонгогч төвтэй үйл ажиллагааг төлөвшүүлэх, ил тод байдал, хариуцлагыг бэхжүүлэх зарчмыг тууштай баримтлан ажиллах болно.

Ардчиллын чанар нь зөвхөн сонгуулийн үр дүнгээр бус, харин сонгуулийг зохион байгуулж буй байгууллагын шударга байдал, чадавх, хараат бус байдал, олон нийтийн итгэлцлээр хэмжигддэг. Иймээс эдгээр үнэт зүйлсийг бэхжүүлэх нь миний үйл ажиллагааны тэргүүлэх зорилт байх болно.

Мөн Монголын ард түмний хөгжин дэвжих хүсэл тэмүүлэл, ардчилсан хөгжлийн үнэт зүйлсийг бататгах үйл хэрэгт өөрийн мэдлэг, туршлагаа зориулж, Сонгуулийн Ерөнхий Хорооны үйл ажиллагааг шинэ шатанд гаргах, институцийн чадавхыг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулахын төлөө ажиллана. Түүнчлэн Сонгуулийн Ерөнхий Хорооны гишүүнд нэр дэвшүүлж буй байгууллагынхаа итгэл найдвар, хүлээлгэсэн хариуцлагыг бүрэн ухамсарлаж, төрийн албаны ёс зүй, хараат бус байдал, мэргэжлийн зарчмыг эрхэмлэн ажиллах болно.

Нийт 678 үг

Хавсралт:

Холбогдох хуульд заасан шаардлагыг хангасныг нотлох дараах болон бусад баримт бичгийг нэр дэвших тухай хүсэлтэд хавсаргана:

- төрийн албан хаагчийн анкет;
- эрх бүхий байгууллагаас нэр дэвшүүлсэн албан бичиг, шийдвэр;
- иргэний үнэмлэхийн хуулбар;
- нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар, эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг;
- боловсролын зэргийн дипломын хуулбар;
- хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг;
- тухайн албан тушаалыг хашихад шаардлагатай түвшний мэдлэг, чадвар, туршлага, ёс зүйтэй гэдгийг нотлон харуулсан 10-аас доошгүй тодорхой үйл ажиллагааны талаарх баримт;
- энэхүү загварт заасан баримт бичиг;
- холбогдох бусад баримт.

Хүсэлт гаргагч:

Эцэг/эхийн нэр: ЦЭЦЭГМАА
Өөрийн нэр: УРТНАСАН

Гарын үсэг:
Он, сар, өдөр: 2026-06-09

